

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ “ШИЛЖИН ЯВАХ ЦОМ-2024” СПОРТЫН ЗУРГААН ТӨРӨЛТ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

2024 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

Монголын Хуульчдын Холбооны Зөвлөл, Чиг үүргийн болон Сайн дурын хороод, Тамгын газар, орон нутгийн салбарын гишүүдийн дунд спортын 6 төрлөөр /сагсан бөмбөг, гар бөмбөг, дартс, боулинг, биллиард, ширээний теннис/ “Шилжин явах цом”-ын төлөөх тэмцээнийг 2024 оны 05 дугаар сарын 23,24,25,26-ны өдрүүдэд зохион байгуулна.

Нэг. Тэмцээний зорилго

1.1 Монголын Хуульчдын холбооны Зөвлөл, Чиг үүргийн болон Сайн дурын хороод, Тамгын газар болон орон нутгийн салбар хуульчдын дунд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрыг хөгжүүлэх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, спортын талбарт шударгаар өрсөлдөх, мэргэжил нэгт нөхөдтэйгөө танилцахад оршино.

Хоёр. Тэмцээний төрлүүд

2.1 Тэмцээнийг дараах төрлөөр зохион байгуулна.

2.1.1. Дартс /эрэгтэй 1, эмэгтэй 1/

2.1.2. Боулинг /эрэгтэй 3, эмэгтэй 2/

2.1.3. Биллиард /эрэгтэй 1, эмэгтэй 1/

2.1.4. Ширээний теннис /эрэгтэй 1, эмэгтэй 1, холимог хос/

2.1.5. Волейбол /эрэгтэй, эмэгтэй баг/

2.1.6. Сагсан бөмбөг /эрэгтэй, эмэгтэй баг/

Гурав. Тэмцээн зохион байгуулах журам

3.1. Дартс

3.1.1. Дартсын тэмцээнд зөвхөн хорооны дарга, тэргүүн, удирдах зөвлөлийн гишүүдээс оролцоно. /Орон нутгаас баг оролцох бол салбарын зохицуулагч нар бүсчилж нэгдэж орж болно./

3.1.2. Тоглогчид ээлжлэн 3, 3 сум тавьж өрсөлдөх бөгөөд 301 онооноос эхэлж авсан оноогоо хасах журмаар хэн түрүүлж 0 оноотой болсон нь хожно. 0 оноонд хүрэх сүүлийн сумаа заавал бухын нүд, эсвэл 2 дахин үржүүлж авах нарийн хэсэгт онож, 0 оноотой болж дуусгана.

3.1.3 Өрсөлдөгч нар шодож хэн түрүүлж шидэхээ шийдвэрлэх бөгөөд самбарын төвд хэн ойр сумаа шидсэн нь тоглолтыг эхлүүлнэ.

3.2. Боулинг

3.2.1. Тэмцээнд баг тус бүрээс эрэгтэй 3, эмэгтэй 2 тамирчин оролцоно.

3.2.2. Багуудын тоглох замыг сугалаагаар шийднэ.

3.2.3. Тэмцээнийг зохион байгуулагчдаас томилогдсон шүүгч шүүнэ.

3.2.4. Шидэлтийн үед пин дутуу тавигдсан, пин унаж хэвтээ байрлалтай болсон тохиолдолд шүүгчид заавал мэдэгдэх бөгөөд пин гүйцэд тавигдсаны дараа шидэлтийг хийнэ. Шүүгчид мэдэгдэлгүйгээр шидсэн тохиолдолд тухайн оноог хасаж тооцно.

3.2.5. Тэмцээн 2 үе шаттай явагдах бөгөөд эхний шатаас хамгийн өндөр оноо авсан 4 баг шигшээ тоглолтод оролцох эрхээ авах бөгөөд хоёрдугаар шатанд оролцох багуудын эхний шатанд авсан оноо шигшээ тоглолтод нөлөөлөхгүй.

3.2.6. Тэмцээнд оролцогч гишүүдийн эхний тоглолтын хувийн оноогоор шилдэг эрэгтэй, эмэгтэй тоглогчийг шалгаруулна.

3.3. Биллиард

3.3.1 Ганцаарчилсан эрэгтэй төрөл 10 улаан бөмбөгөөр 3 удаа тоглоно. Түрүүлж хожсон нь ялна.

3.3.2 Эмэгтэй ганцаарчилсан төрөл 3 улаан бөмбөгөөр 3 удаа тоглоно. Түрүүлж 2 хожсон нь ялна.

3.4. Ширээний теннис

3.4.1. Эрэгтэй, ганцаарчилсан, Эмэгтэй ганцаарчилсан, Холимог хос

3.4.2. Холбооны дэргэдэх 20 хороо бүрээс 2 эрэгтэй, 2 эмэгтэй тамирчид, 1 дасгалжуулагч оролцоно.

3.4.3. Нэг бүрчилсэн болон холимог хосын тоглолтууд 2 шатлалтай явагдана.

3.4.4. Эхний шатанд нэг бүрчилсэн болон хос тоглогчид хэсгүүдэд хуваагдан ТОЙРГООР тоглоно

3.4.5. Хоёр дахь шатанд хэсэг тус бүрээс эхний 2 байр эзэлсэн тоглогчид ХАСАГДАХ системээр тоглож аваргууд тодорно.

3.4.6. Эхний шат хэсгийн тоглолтууд 11 оноогоор 3 сет буюу хэн эхэлж 2 сет хожсоноор харин хасагдах шатны тоглолтууд 5 сет буюу хэн эхэлж 3 сет хожсоноор ялагчийг тодруулна.

3.5. Волейбол

3.5.1. Волейболын тэмцээнд эрэгтэй 8, эмэгтэй 8 тамирчнаас бүрдсэн 8 гишүүний бүрэлдэхүүнтэй баг оролцоно. Талбай дээр 6 эрэгтэй, 6 эмэгтэй тамирчин гарч тоглоно.

3.5.2. Хэсгийн тоглолтууд 15 оноогоор, шигшээ тоглолтууд 21 оноогоор явагдана. Хэн эхэлж 2 сет хожсон нь ялна

3.5.3. Нэг баг 1 үед 1 удаа минутын амралт авах эрхтэй.

3.6. Сагсан бөмбөг

3.6.1. Сагсан бөмбөгийн төрөлд баг тус бүр эрэгтэй 6-8, эмэгтэй 6-8 гишүүнтэй оролцоно.

3.6.2. Багийн бүрэлдэхүүн нь талбай дээрх тамирчдын тоо 40 наснаас дээш 2-оос доошгүй байна. */Насны ангиллын доод хязгаар 1984 оны 01 сарын 01-с хойш төрсөн байна/.*

3.6.3. 2 үеэр тоглоно. Тоглолтын цаг, минут, зааварт заагдаагүй бусад асуудлыг техникийн зөвлөгөөн дээр эцэслэн шийдвэрлэнэ.

3.6.4. Тэмцээнд оролцож буй баг тамирчид тэмцээний төрөл тус бүрд зөвхөн Хуульчдын холбооны гишүүдээс бүрдсэн багийг оролцуулна. Гишүүн биш тамирчин оролцуулсан тохиолдолд тухайн төрөлд тус багийг хасах ба тухайн төрлийнхөө багийн онооноос хасагдана.

Дөрөв. Тэмцээн дүгнэх журам

4.1. Тэмцээний төрөл бүр дээр 1, 2, 3 дугаар байр шалгаруулж, багийн дүнг төрөл тус бүрээр нэгтгэж, нийлбэр дүнгээр 3 байр эзлүүлэн шагнаж урамшуулна.

4.2. Тэмцээний төрөл тус бүрд

1-р байр: Өргөмжлөл, алтан медаль, мөнгөн шагнал

2-р байр: Өргөмжлөл, мөнгөн медаль, мөнгөн шагнал

3-р байр: Өргөмжлөл, хүрэл медаль, мөнгөн шагнал олгоно.

4.3. Тэмцээнд оролцогч багуудын 6 төрлийн тэмцээний нийлбэр дүнгээр нь байр эзлүүлж, түрүүлсэн багт шилжин явах цом гардуулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнах бөгөөд 2, 3-р байр эзэлсэн багт өргөмжлөл, мөнгөн шагнал олгоно.

4.4. Багуудын оноо тэнцсэн тохиолдолд эмэгтэй багийн амжилтыг харгалзан үзнэ.

Тав. Тэмцээн зохион байгуулах хугацаа

5.1. Биллиардны тэмцээн 2024 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 09 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороолол, Ардчиллын ордны зүүн талд “Бодь” снүүкер клубт эхэлнэ.

5.2. Боулингийн тэмцээн 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 13 цагт “Парк боулинг” төвд эхэлнэ.

5.3. Дартсын тэмцээн 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр 13 цагт “Парк боулинг” төвд эхэлнэ.

5.4 Ширээний теннисний тэмцээн 2024 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 09 цагт “Наадам клуб, Хүннү 2222 салбар” спорт зааланд эхэлнэ.

5.3. Волейболын тэмцээн 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр 08 цагт “Наадам клуб, Хүннү 2222 салбар” спорт зааланд эхэлнэ. (Тэмцээний нээлтийн үйл ажиллагаа тус өдрийн 11:30 цагаас эхлэх тул баг тамирчид бүрэн бүрэлдэхүүнтэйгээр оролцохыг анхаарна уу!)

5.4. Сагсан бөмбөгийн тэмцээн 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 14 цагт (цаг өөрчлөгдөх магадлалтай) эхэлнэ. Сагсан бөмбөгийн медалийн төлөөх тоглолтууд 2024 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 09 цагт “Наадам клуб, Хүннү 2222 салбар” спорт зааланд эхэлнэ.

5.5. Тэмцээн эхлэх цагаас 30 минутын өмнө бага тамирчид тэмцээн болох зааланд ирсэн байхыг анхаарна уу!

Зургаа. Бусад зүйл

6.1. Тэмцээний шагналын сан нь тэмцээнд оролцогч багуудаас төлөх хураамж /бооцооны мөнгө/, Монголын Хуульчдын холбооны Тамгын газраас гаргах зохион байгуулалтын зардлаас бүрдэнэ. Энэхүү шагналын санг бүрдүүлэхийн тулд баг тус бүр 500.000 /таван зуун мянган/ төгрөгийн бооцооны хураамж төлнө.

6.2. Тэмцээний техникийн зөвлөгөөнийг 2024 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн 16:00 цагт Монголын Хуульчдын холбооны 402 тоотод зохион байгуулна. Техникийн зөвлөгөөнд багын ахлагч, дасгалжуулагч нар багын мэдүүлгийг авчран оролцоно.

6.3. Тэмцээнд оролцох баг, тамирчид бооцооны мөнгө төлсөн баримт, тэмцээнд оролцох баг тамирчдын мэдүүлгийг Техникийн зөвлөгөөнд тухайн хорооны багийн ахлагч ирэхдээ авч ирнэ.

6.4. Дартс, боулингийн тэмцээнд оролцох баг тамирчид нэг өнгийн жигд, сагсан бөмбөг, волейболын тэмцээнд оролцох баг тамирчид хувийн дугаар бүхий нэг өнгийн жигд хувцастай байна.

6.5. Тэмцээний нээлтийн үйл ажиллагаа тус өдрийн 11:30 минутаас эхлэх тул баг тамирчид бүрэн бүрэлдэхүүнтэйгээр оролцохыг анхаарна уу!

6.6. Хэсгийн хуваарилалт болон сугалааг техникийн зөвлөгөөнөөр тэмцээнийг шүүн явуулах шүүгч зохион байгуулна.

6.7. Тэмцээний тоглох цаг хугацаа, явагдах газар болон зохион байгуулалт, шүүлттэй холбоотой бусад асуудлыг техникийн зөвлөгөөн дээр болон зохион байгуулах ажлын хэсэг шийдвэрлэнэ.

6.8. Тэмцээнтэй холбоотой хүсэлтийг багийн ахлагч, дасгалжуулагчаар уламжилж тэмцээний зохион байгуулалтын ерөнхий шүүгчид гаргана.

6.9. Тэмцээн эхлэх цагаас 30 минутын өмнө бага тамирчид тэмцээн болох зааланд ирсэн байхыг анхаарна уу!

6.10. Төлбөр тушаах данс: Худалдаа хөгжлийн банк -
499218869 Хүлээн авагч: Монголын Хуульчдын холбоо

Гүйлгээний утга: Тэмцээний бооцооны мөнгө, Хорооны болон багийн нэр
Холбоо барих: Зохион байгуулах ажлын хэсгийн гишүүн Т.Гүнбилэг- 95800707